



## ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №17



2019 оны 5 дугаар сарын 27-31

### НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2019 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт 620 яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 87(14%) галзуугийн эрсдэлд өртсөн, 518(83.5%) хачигт халдвар, 4(0.6%) боом, 3(0.5%) тарваган тахал, 2(0.3%) хумхаа, 1(0.2%) ям, 2(0.3%) денги, 3(0.5%) бэтэг өвчний сэжигтэй тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

#### 1.1. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:



Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн 22 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт 87 тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 45%-иар, эпидемиологийн 21 дүгээр долоо хоногтой харьцуулахад 2 тохиолдлоор тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.



Галзуу өвчний сэжигтэй зэрлэг, мал амьтанд уруулж, ноцуулан, шүлсдүүлсэн хүмүүсийн тохиолдлыг эх уурхайгаар нь авч үзвэл: эзэнтэй нохойд (40.2%), чононд (20.7%), эзэнгүй нохойд (13.8%), үнэгэнд (9.2%), үхэрт (4.6%), мануулд (3.4%), мууранд (2.3%), тэмээнд (1.1%) нь уруулж, ноцуулж вакцин, ийлдэс эмчилгээнд хамрагдсан байна.

## 1.2 Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:

Архангай, Баянхонгор, Булган, Баян-Өлгий, Дорнод, Дундговь, Дорноговь, Дархан-Уул, Говьсүмбэр, Говь-Алтай, Өмнөговь, Өвөрхангай, Ховд, Хэнтий, Хөвсгөл, Завхан, Сэлэнгэ, Төв, Увс, Орхон, Сүхбаатар аймгийн 116 сум, нийслэлийн 7 дүүрэгт хачгаар дамжих халдварын 518 сэжигтэй тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 27.1%-иар, эпидемиологийн 21 дүгээр долоо хоногтой харьцуулахад 66 тохиолдлоор тус тус буурсан үзүүлэлттэй байна.



2019 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ХР-ын 442 сэжигтэй тохиолдлын 33(7.5%), ХБ-ын 47 сэжигтэй тохиолдлын 13(27.6%), ХЭ-ын 29 сэжигтэй тохиолдол 3(10.3%) тархвар судлал, эмнэлзүй, лабораторийн шинжилгээгээр онош батлагдсан байна.

### 1.3 Мэрэгч амьтны дуудлага:

2019 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийслэлийн ЧД-ийн 19-р хорооноос ирүүлсэн мэрэгч амьтны (1 ширхэг тарвага) дуудлаганд үйлчилсэн. Сорьцод онош тодруулахаар лабораторийн шинжилгээ хийж байна

#### Монгол улсад:

##### Галзуу өвчний мал, амьтны өвчлөл:

Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын Баян-Улаан багийн “Яншаа” гэдэг газар малчин “Ц”-ын 1 үхэр 2019 оны 5 дугаар сарын 23-ны өдөр галзуу өвчний шинж тэмдэгтэй хорогдсон тул сорьц авч аймгийн МЭАЦЛ-д шинжлүүлэхэд галзуу өвчин болох нь тогтоогдсон. Тус сумын Засаг даргын захирамжаар 5 дугаар сарын 24-ний өдрийн А/71 дүгээр захирамжаар 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоосон. Голомтонд нийт 591 толгой малыг вакцинжуулсан байна.

Эх сурвалж: ОБЕГ

##### Галзуу өвчний мал, амьтны өвчлөл:

Өвөрхангай аймгийн Гучин-Ус сумын Хөөвөр багийн “Мааньтын нуруу” гэдэг газар малчин “Д”-ийн 1 тэмээ 2019 оны 5 дугаар сарын 28-ны өдөр галзуу өвчний шинж тэмдэгтэй хорогдсон тул сорьц авч аймгийн МЭАЦЛ-д шинжлүүлэхэд галзуу өвчин болох нь тогтоогдсон. Тус сумын Засаг даргын захирамжаар 5 дугаар сарын 29-ний өдрийн А/37 дугаар захирамжаар 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоосон байна.

Эх сурвалж: ОБЕГ, Өвөрхангай ЗӨСТ

##### Галзуу өвчний мал, амьтны өвчлөл:

Хэнтий аймгийн Биндэр, Өмнөдэлгэр, Бэрх, Норовлин сумдад галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт 13 хүн вакцинд хамрагдсан байна. Тус сумдын нийт 180 хүн амд галзуу, боом, хачигт халдварт өвчнөөр сургалт сурталчилгаа зохион байгуулан ажилласан.


Эх сурвалж: Хэнтий ЗӨСТ

## ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ


#### Олон улсад:

##### Эбола вируст халдвар:

2019 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсад Эбола вируст халдварын сэжигтэй тохиолдол 1866 тохиолдол бүртгэгдэж, үүнээс 1241 (67%) нь нас барсан. Нийт тохиолдлын 1051 (56%) нь эмэгтэйчүүд, 545 (30%) нь 18-аас доош насны хүүхдүүд эзэлж байна. Тус улсад тандалт судалгаа үргэлжилж байна.



Хүснэгт 1. Эпидемиологийн долоо хоногоор



Зураг 1. Эбола вирус халдварын тархалт, БНАК улс

Эх сурвалж: ДЭМБ

**Шувууны томуу өвчин:**


ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2019 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн мэдээгээр БНХАУ-ын Жанхуа мужийн шувууны аж ахуйд шувууны томуу (H5N2) өвчний дэгдэлт бүртгэгдсэн байна. Нийт мэдрэмтгий 3944 шувуу өртөмхий байснаас 2136 шувуу өвчилж 2136 шувуу өвчилж үхэн 1808 шувууг устгасан байна.



Эх сурвалж: ДМАЭМБ

**Африкийн гахайн мялзан:**

ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2019 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн мэдээгээр ОХУ-ын Калининград мужийн ойд 5 дугаар сарын 14-нд африкийн гахайн мялзан өвчин бүртгэгдсэн байна. Нийт 2 зэрлэг гахай өвчилж үхсэн байна.



**Африкийн гахайн мялзан:**

ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2019 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн мэдээгээр Вьетнам улсын Винх Дуанг тосгоны гахайн аж ахуйд 5 дугаар сарын 21-нд Африкийн гахайн мялзан өвчин бүртгэгдсэн байна. Нийт 1162 гахайг устгасан байна.



### **Малын шүлхий:**

ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2019 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн мэдээгээр Ливи улсын Гхарьян тосгоны аж ахуйд 5 дугаар сарын 20-нд шүлхий өвчин бүртгэгдсэн байна. Нийт 120 хонь өртөмхий байснаас 5 хонь өвчилж үхсэн байна.



Эх сурвалж: ДМАЭМБ

### **MERS-CoV-ийн халдвар:**

2019 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн Саудын Араб улсын ЭМЯ-ны 22 дугаар долоо хоногийн эргэн мэдээллээр MERS-CoV-ийн халдварын 2 тохиолдол бүртгэгдсэн. Тархвар судлалын холбогдлыг тогтоох ажил үргэлжилж байна.

#### Эхний тохиолдол:

- 64 настай, эрэгтэй. Риядх дүүрэгт амьдардаг.

#### Хоёрдах тохиолдол:

- 26 настай, эрэгтэй. Кассим дүүрэгт амьдардаг.



Эх сурвалж: Promed